# НИЙСЛЭЛИЙН
# ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 11 өдөр Дугаар В/562 Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны
"Дотны туслагч" өрхийн эрүүл мэндийн
төвийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг,Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 7 нэр төрлийн 2,576,000.0 /Хоёр сая таван зуун далан зургаан мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны "Дотны туслагч" өрхийн эрүүл мэндийн төв /Ч.Цэрэндолгор/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 2 нэр төрлийн 86,000.0 /Наянзургаан мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 5 нэр төрлийн 2,490,000.0 /Хоёр сая дөрвөн зуун ерэн мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, Удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны "Дотны туслагч" өрхийн эрүүл мэндийн төв /Ч.Цэрэндолгор/-д даалгасугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ҮНЭНБАТ

E:\01.23 Tushaalin tusul\uj-7\Tushaal-1\tushaal-3.dc

1119282495 2576589

1150500011487

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 10.... дугаар сарын 11...өдрийн A/562...тоот тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны "Дотны туслагч"ӨЭМТ

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | ЭБХХХКХ-ын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өнгөт принтер | 7 | 1 | 289,000 | 289,000 | 289,000 | - | татах |
| 2 | Компьютерийн процессор | 9 | 1 | 605,000 | 605,000 | 605,000 | - | татах |
| 3 | Компьютер | 9 | 1 | 656,000 | 656,000 | 656,000 | - | татах |
| 4 | Бичил долгионы зуух | 10 | 1 | 190,000 | 190,000 | 190,000 | - | татах |
| 5 | УВЧ | 10 | 1 | 750,000 | 750,000 | 750,000 | - | татах |
| | дүн | | | | 2,490,000 | | | |
| 6 | Ном | 10 | 1 | 36,000 | 36,000 | 36,000 | - | устгах |
| 5 | Сургалтын сандал | 10 | 2 | 25,000 | 50,000 | 50,000 | - | устгах |
| | Дүн | | | | 86,000 | | | |
| | **Нийт дүн** | | | | **2,576,000** | 2,576,000 | - | |
| | Үүнээс: Устгах хөрөнгийн дүн | | | | **86,000** | | | |
| | Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн | | | | **2,490,000** | | | |